



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

д/о 13 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 215

Мандалговь

Хөрөнгө актлах тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дугаар заалт, Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахд баримтлах журмын 3.2.6 дугаар заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. "Дундговь-Ус" ОНӨҮГ-ын хэрэгцээнд ашиглагдаж байсан CLW5081ZVS маркын ДУА 39-60 улсын дугаартай хог тээврийн 35'631'750 төгрөгний анхны өртөгтэй 869'679 төгрөгний үлдэгдэл өртөгтэй автомашиныг актлан даснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Уг автомашиныг бүртгэлээс хасч, ашиглаж болох эд ангийг үнэлэн байгууллагын эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авах, пункерыг бохир ус сорох зориулалтын ДУА 39-08 улсын дугаартай машинд тавьж хог тээврийн машины зориулалтаар ашиглахыг "Дундговь-Ус" ОНӨҮГ-ын захирал /Р.Энхмаа/ - д үүрэг болгосугай.

3. Хөрөнгө данс бүртгэлээс хасах, зориулалтыг өөрчлөх ашиглах, ашиглаж болох эд ангийг үнэлэн бүртгэх ажилд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн алба /П.Очирбат/ - д даалгасугай.

ДАРГА  С.БУДЖАВ



0100000540